

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН
2015 ОНЫ ЭХНИЙ 8 САРЫН ДҮНГИЙН
ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА**



МӨНГӨ, БАНК, ДААТГАЛ

2015 оны эхний 8 сарын байдлаар аймгийн төсвийн орлогын дүн 4843.2 сая төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 168.9 сая төгрөгөөр буюу 3.6 хувиар өссөн байна. 2015 оны эхний 8 сарын байдлаар нийт орлогын болон татварын орлогын төлөвлөгөөг Эрдэнэцогт, Шинэжинст, Жаргалант, Богд, Баянлиг, Өлзийт, Бууцагаан сумууд биелүүлсэн байна.

Орлогын төлөвлөгөөний биелэлтийг төрөл дээр нь авч үзвэл: НӨАТатвар 71.4 сая төгрөг, агаарын бохирдол 4.2 сая төгрөг, ашигт малтмал 206.7 сая төгрөг, ЦХТА орлого 227.2 сая төгрөг, АТӨЯХ-н татвар 41.4 сая төгрөг, ҮХЭХ-н татвар 8.7 сая төгрөг, газрын төлбөр 19.6 сая төгрөг, ИОТТХ 15.4 сая төгрөг, патент 2.7 сая төгрөг, хог хаягдлын хураамж 53.7 сая төгрөг, нохойн татвар 2.8 сая төгрөг, бууны татвар 2.9 сая төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 2.2 сая төгрөг, газрын дуудлага худалдаа 99.1 сая төгрөг, түгээмэл тархацтай АМАТ 38.6 сая төгрөг, ус ашигласны төлбөр 117.7 сая төгрөг, ҮХЭХ борлуулсны 19.9 сая төгрөгөөр тус тус тасарч бусад нэр төрөлд биелэлээ.

Нийт орлогод ААНБ-н орлогын албан татвар 2.9 хувь, нэмүү өртгийн албан татвар 6.6 хувь, ЦХТА орлого 58.0 хувь, авто тээвэр өөрөө авагч хэрэгслийн татвар 6.2 хувь, хүү торгууль 6.9 хувь бусад төлбөр хураамж 19.4 хувийг эзэлж байна.

2015 оны 8 дугаар сарын эцэст иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 46893.9 сая төгрөгт, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 119085.4 сая төгрөгт хүрчээ. Чанаргүй зээл 897.1 сая төгрөгт хүрсэн нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 0.8 хувийг эзэлж байна.



ЭРҮҮЛ МЭНД

2015 оны эхний 8 сарын байдлаар аймгийн хэмжээнд 1434 хүүхэд төрсөн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1.8 хувиар бага байна.

Эхний 8 сарын байдлаар архаг болон цочмог халдварт өвчний гаралтыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад салхин цэцэг 99, тэмбүү 92, арьсны мөөгөнцөр 29, трихоминиаз 9, бруцеллёз 4, сүрьеэ 5, хүйтэн 24 тохиолдлоор өссөн бол гар хөл амны өвчин 4, гахайн хавдар 1, суулгалт халдвар 1 тохиолдлоор тус тус буурсан байна.

Эхний 8 сард нас баралтын 314 тохиолдол бүртгэгдсэн ба үүнээс эмнэлэгт нас баралт 24.5 хувийг эзэлж байна.

Түргэн тусламжийн дуудлага өнгөрсөн оны эхний 8 сард 10959 байсан бол энэ оны эхний 8 сарын байдлаар 9583 болж 1376 дуудлага буюу 12.6 хувиар буурсан байна.



АЖ ҮЙЛДВЭР

2015 оны эхний 8 сарын байдлаар аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт 2437918.0 мянган төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 78160.0 мянган төгрөгөөр буюу 3.1 хувиар буурчээ.

Эхний 8 сарын байдлаар аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг авч үзэхэд урьд оны мөн үеэс нарийн боов 12.3 тн-оор, талх 34.2 тн-оор, хоормог 4.6 мян.литр, тараг 0.2 мян.литр, түгээсэн цэвэр ус 4.3 мян.м3-ээр тус тус өссөн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулалт өссөн дүнгээр /мян.төг/

	Наймдугаар сар		
	2014	2015	2015.08/2014.08
Нийт борлуулалт	2516078.0	2437918.0	96.9

Аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт /өссөн дүнгээр/

Бүтээгдэхүүний нэрс	хэмжих нэгж	Наймдугаар сар		
		2014	2015	2015.08/2014.08
Тараг	Мян.л	1.7	1.9	111.8
Хоормог	Мян.л	0.6	5.2	866.7
Нарийн боов	тн	34.3	46.6	135.9
Талх	тн	45.8	80.0	174.7
Түгээсэн цэвэр ус	Мян.м3	140.3	144.6	103.1



НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

2015 оны эхний 8 сард тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэрт 14296.2 сая төгрөг, тахир дутуугийн тэтгэвэрт 2775.0 сая төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 1172.3 сая төгрөг, цэргийн тэтгэвэрт 243.7 сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжид 30.5 сая төгрөг, жирэмсэн болон амаржсаны тэтгэмжид 620.0 сая төгрөг, оршуулгын тэтгэмжид 152.5 сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэрт 40.7 сая төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 14.4 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмжид 147.8 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас эмчилгээний эмийн зардалд 2165.2 сая төгрөг,

рашаан сувиллын зардалд 270.0 сая төгрөг, эмийн үнийн хөнгөлөлтөд 225.0 сая төгрөг тус тус олгожээ.

Нийгмийн халамжийн сангаас 2015 оны эхний 8 сард 6282 хүнд 3546.0 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр болон нөхцөлт мөнгөн тэтгэмж олгосон байна. 2015 оны эхний 8 сард нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай 8376 иргэнд 1203.9 сая төгрөгийн хөнгөлөлт, мөнгөн тусламж, 773 ахмадад 257.1 сая төгрөгийн нэг удаагийн хөнгөлөлт тусламж, хөгжлийн бэрхшээлтэй 189 иргэнд 70.9 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж тус тус олгожээ.



ГЭМТ ХЭРЭГ

2015 оны эхний 8 дугаар сарын байдлаар 14-17 насны 22 хүн, 18-аас дээш насны 239 хүн гэмт хэрэгт холбогдсон. Гэмт хэргийн улмаас 253 иргэн хохирсон ба 14 хүн нас барж, 112 хүн гэмтсэн. Нийт 325.5 сая төгрөгийн хохирол учирснаас 196.1 сая төгрөгийг төлүүлж, хохирол нөхөн төлүүлэлт 60.2 хувьтай байна.

Эхний 8 сард аймгийн хэмжээнд нийт 245 хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 67 нэгжээр буюу 21.5 хувиар буурсан.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 143 буюу 58.3 хувь нь Баянхонгор суманд, 102 буюу 41.6 хувь нь бусад суманд гарсан.

Хэргийн илрүүлэлт 63.3 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0.4 пунктээр өссөн. Хэргийн гаралт 12 суманд буурч, 3 суманд өсөж, бусад суманд ижил түвшинд байна. Хүнийг санаатай алах гэмт хэрэг 1 нэгжээр буюу 33.3 хувь, бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг 20 нэгжээр буюу 19.6 хувь, хүчин 3 нэгжээр буюу 42.8 хувь, иргэдийн өмчийн хулгай 8 нэгжээр буюу 13.3 хувь, залилан 1 нэгжээр буюу 25.0 хувь, танхай 12 нэгжээр буюу 75.0 хувь, хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 21 нэгжээр буюу 56.7 хувь, бусад гэмт хэрэг 13 нэгжээр буюу 26.0 хувь, насанд хүрээгүй хүнээс үйлдсэн гэмт хэрэг 11 нэгжээр буюу 33.3 хувь тус тус буурсан байна.

Харин өмчийн хулгайн гэмт хэрэг 4 нэгжээр буюу 4.7 хувь, малын хулгай 10 нэгжээр буюу 55.5 хувиар тус тус өссөн байна. Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцогдвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэрэг 17 нэгжээр буюу 44.7 хувиар өссөн байна.



ХӨДӨӨ АЖ АХУЙ

Хураасан ургац /тонноор/

Сум/дүүрэг	Төмс	Бэлтгэсэн өвс	Бэлтгэсэн дарш	Гар тэжээл	Хужир шүү	Хүнсний ногоо	байцаа	лууван	шар манжин	сонгино	өргөст хэмх	улаан лооль	тарв ас	амтат гуа
Баянхонгор		148		0.5	11.4									
Баацагаан		20.3		1.75	60.6	13.8					6.6	5	2.2	
Баянбулаг		11		3										
Баянговь		11		1										
Баянлиг	3													
Баян-Овоо		9		1.5	8									
Баян-Өндөр		11.5		4										
Баянцагаан		12		3										
Богд		200												
Бөмбөгөр		52												
Бууцагаан						65					65			
Галуут		71	8											
Гурванбулаг		10												
Жаргалант		10		0.5										
Жинст		51												
Заг		33		2										
Өлзийт	5.5					2.1	1	0.5	0.5	0.1				
Хүрээмарал		68		9.9										
Шинэжинст						2.4						2	0.3	0.1
Эрдэнэцогт		15.3		2.1										
	8.5	733.1	8	29.25	80	83.3	1	0.5	0.5	0.1	71.6	7	2.5	0.1

Нийслэл и шийтгэл ойлгоу й хийж, 8 хувиар, хувиар хувиар хувиар

хувиар

хувиар хувиар	НА хувиар хувиар	хувиар хувиар хувиар	Н хувиар хувиар хувиар	л хувиар хувиар хувиар	хувиар хувиар хувиар хувиар	хувиар хувиар хувиар хувиар	с хувиар хувиар	Н хувиар хувиар хувиар хувиар	Л хувиар хувиар хувиар хувиар	з хувиар хувиар хувиар хувиар	хувиар хувиар хувиар хувиар	з хувиар хувиар хувиар хувиар
99.5	93.3	96.8	99.9	104.3	104.2	104.2	100.0	100.0	100.0	104.3	100.0	104.3

СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС